

Чацаргана хөтөлбөр

Чацаргана түүний ашиглалт судалгааны өнөөгийн байдал: Бүх төрлийн жимс жимсгэний дотроос манай орны байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалд нэн зохицсон ургамал бол чацаргана юм. Чацарганы найрлагад С, А, К, Е, В, Р бүлгийн витамин тос, биологийн идэвхит бодис, амин хүчил агуулагддаг. Чацаргана нь хүнсний болон эм, гоо сайхны олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үнэт түүхий эд болдог.

1976 онд явуулсан судалгаагаар Монгол орны баруун хойт, хойт хэсэгт байрлах томоохон голуудын сав газруудад 30 мянга шахам га талбайд зэрлэгээр ургаж байсан бол хүмүүсийн буруу үйл ажиллагаа, ган усны үертэй холбогдон энэ талбайн хэмжээ эрс багасжээ.

1965 онд Алтайн хязгаараас таримал Чацарганы хэд хэдэн сортын суулгац авч, мөн Монгол орны байгалийн чацарганы сонгомол дүрсүүдийг цуглуулж Улаангомын ХАА-н нэгдсэн туршлага станцын талбайд тариалснаар чацарганы тартмал цэцэрлэг байгуулах ажил эхэлжээ. Улаанбаатар хот, Увс, Ховд, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл, Говь-Алтай, Хэнтий, Дорнод, Баянхонгор, Төв аймгийн нутгийн хэд хэдэн цэгт чацаргана ургаж ургац өгч байна.

1964 оноос Увс аймагт чацаргана судлалын суурь тавигдаж төрийн соёрхолт, доктор Б.Лааган ОХУ-ын Алтайн хязгаар, Барнаулын жимс жимсгэний хүрээлэн, Горно-Аптайн жимсний станцтай харилцаа тогтоож харьцуулсан судалгаа туршилт явуулж тус бүс нутагт чацарганы Масличная, Витаминная, Щербинка сортуудыг нутагшуулж суулгац үржүүлгийн эхлэл тавигдсан байна. 1986 онд Орос-Монголын эрдэмтэд хамтран чацарганы морфологи, биологи, селекц, биохими, технологийн иж бүрэн судалгаа явуулж эх орны “Чандмань”, “Улаангом”, “Тэс” сортыг гарган авсан байдаг. Чацарганы суулгац бэлтгэх арга, тоног төхөөрөмжийн судалгаа явуулж хүлэмжийн нөхцөлд ногоон мөчир үржүүлэх замаар суулгац бэлтгэж болохыг тогтоосон нь чацаргана тариалалтыг нэмэгдүүлэх үндэс суурь болж өгсөн. 1980-1990-аад оны эцэс гэхэд Увс аймаг 500 га-ийн услалтын систем бүхий 360 га-ийн чацарганы иэцэрлэгтэй болж жилд 300 гаруй тн чацаргана хурааж байлаа.

Тус аймгийн чацарганы судалгааг олон эрдэмтэд тал бүрээс нь судалсан. Тухайлбал Б.Лааган, Б.Бат-Очир нар селекц, сорт судалгаа, суулгац ургуулах технологи, Ч.Авдай, Б.Балган нар чацаргана хураах, тариалах ажлын механикжилт, Б.Сүрэнхор, Төмөр, Батаа нар чацаргана боловсруулах техник.технологи, Цэндээхүү Увсын чацарганы биологи, морфологи, биохими, Долгорсүрэн, Г.Баяраа нар чацаргана тариалах технологи /услах, бордох, хөрс боловсруулах/ асуудлаар судалгаа хийж 7 хүн эрдмийн зэрэг хамгаалж, 30 гаруй шинэ бүтээлийн патент авч, 5 хүн төрийн соёрхол хүртсэн. Энэ ажлын хүрээнд ном товхимол гарын авлагатай болж оюуны зохих нөөцийн сан бүрдсэн.

Тус аймагт байгалийн чацарганыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулж цэвэр тос, стандартын тос, шарз, өтгөрүүлсэн шүүс, витаминь бүрдэл үйлдвэрлэж

Увсын гэсэн тодотголтой нутгийн нэгэн өвөрмөц бүтээгдэхүүн болсоор ирсэн.

Дэлхийн байгалийн чацарганы нөөцийн 80% нь Алтай-Саян- Тагнын нуруу, түүний салбар уулсаас эх авсан гол мөрний сав нутаг, далайн түвшний 1000 м орчимд өргөгдсөн бүс нутаг болох Сибирь, Их нууруудын хотгорт тархсан байдгаас авч үзвэл Чацаргана тариалж илүү үр дүнд хүрэх нутаг бол Увс юм. Байгалийн зэрлэг болон Увсаас бусад нутагт тариалсан чацарганы нэг бутнаас 5-7 кг жимс авдаг байхад “Чандмань” сортын нэг бутнаас 25-30 кг жимс авч байжээ. Эндээс үзэхэд Чацарганы жинхэнэ өлгий нутаг нь Увс аймаг мөн гэсэн хоёр дахь баталгаа болж байна. Олон улсын чацарганы ассоциацийн шугамаар зохиогддог үйл ажиллагаанд оролцож гадаад орнуудтай холбоотой ажиллаж байгаа ч гэсэн Увс аймагт тариалах талбайн хэмжээ өсөхгүй, түүний судалгаа тариалалт ашиглалтын талаар нэгдсэн бодлого үндсэндээ байхгүй байна.

Эрдэмтэн судлаачдын хүчээр Чацаргана боловсруулах 10-аад жижиг үйлдвэр байгуулж, тос, шүүс, поливитамины ханд, дарс, ундаа, Чацарганы шүүсээр баяжуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан боловч ихэнх үйлдвэрүүд түүхий эдийн дутагдал, технологи, тоног төхөөрөмжөө цаашид боловсронгуй болгоогүйн улмаас эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл багасч харин Чацарганыг гар дамжуулан худалдаж иргэд буцалгаж уух байдлаар бага хэмжээгээр ашиглах боллоо.

Гадаад орнуудад хүнс, эмчилгээ гоо сайхны олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөрс эвдрэлээс хамгаалах, тал хээрийг ойжуулахын тулд түүнийг их хэмжээгээр тариалж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр төрөл нь нэмэгдэн эрэлт хэрэгцээ маш түргэн өсч Хятад, Япон, Энэтхэг, Герман, Солонгос зэрэг орны үйлдвэрлэгчид манай улсаас чацарганы жимс, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг авах хөрөнгө оруулах хүсэлт тавих боллоо.

Улсын хэмжээнд 1990-1993 онд тарьмал болон байгалийн талбайгаас жилд 400-500 тн чацаргана хураадаг байсан бол энэ хэмжээ одоо бараг 5 дахин буурчээ. Энэ нь бодлогогүй ажил баримжаагүй болдгын нэгэн илэрхийлэл юм. Иймд энэ чухал бүтээгдэхүүнийг бодлогын түвшинд гаргаж нутгийн бренд болгох асуудлыг шийдвэрлэх цаг үе болсон гэж үзэж энэхүү хөтөлбөрийг боловсруулах нь зүйтэй гэж үзэв.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсын Засгийн газрын болон Увс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг суурин нэг бүтээгдэхүүн”, “Нэг сум нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлж, өрсөлдөх чадвар бүхий чанар сайтай бүтээгдэхүүн бий болгож дотоод, гадаадын зах зээл дээр гаргахыг дэмжихээр заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Чацаргана” хөтөлбөр боловсруулав.

1.2. Нэг тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ нэрд гарсан газрууд дэлхийд төдийгүй манай оронд ч цөөнгүй бий. Тухайлбал Булганы “Сайханы айраг” Өвөрхангайн “Уянгын гэр” гэх зэрэг олон бүтээгдэхүүнийг нэрлэж болох юм. Тэгвэл Увс аймаг улсдаа алдартай “шаргал цай”-тай төдийгүй Увсын чацарганаараа Монголдоо төдийгүй дэлхийд алдарших боломж бий.

1.3. Энэхүү хөтөлбөр нь чацарганыг тарималжуулан зах зээлд гаргаж Увсын брэнд болгоход нийт иргэдийн үүсгэл санаачлагыг өрнүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, иргэн өрх бүрийн орлогыг өсгөх үндсэн дээр ядуурлыг бууруулах

улмаар экологийн цэвэр бүтээгдэхүүн бий болгож дотоодын төдийгүй гадаад зах зээлд өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын баталсан “нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөр, Олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа төслүүдтэй нягт уялдуулах замаар зохион байгуулж үр дүнд хүрэх болно.

1.4 Чацаргана тариалалт, боловсруулалтыг нэмэгдүүлэхийн ач холбогдол. Чацаргана тариалахдаа 1 га талбайд 500-1800 суулгац суулгаж нэг бутнаас 5-7 кг жимс хурааж 1 тн жимснээс 20-70 кг тос, 600 л цэвэр шүүс, 50 кг поливитамины бэлдмэл, 200-250 л амтат дарс, бусад төрлийн бүтээгдэхүүн боловсруулж, мөн өтгөрүүлсэн шүүсийг өөр түүхий эдтэй хольж олон нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой бөгөөд тариалж, хураахад зарцуулсан зардлаа 3-4 жилд нөхдөг, тос болон бусад бүтээгдэхүүнийг гадаад оронд экспортолж эх орны валютын нөөцийг өсгөх, хүн амыг ажлын байртай болгож, ядуурлыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой. Чацаргана Монгол орны аль ч хэсэгт ургадаг, тэсвэртэй, учир хөрс хамгаалах, засгийн газрын “Ногоон хэрэм” хөтөлбөрийн дагуу өргөн тариалж ойжуулалтад ашиглахын хамт жимсийг нь түүж иргэд амьдрал ахуйдаа хэрэглэж, арчилж хамгаалж байх давуу талтай. Нэг га талбайд чацаргана тариалаад зөвхөн жимсээ борлуулсан өрх айл гэхэд 1 жилдээ 12 саяас доошгүй төгрөгийн орлого олох боломжоор хангагдана.

Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, хэрэгжүүлэх хугацаа

2.1 Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

2.1.1 Байгалийн тос ихтэй чацарганы өлгий нутаг нь Монгол, ОХУ -ын Буриад, Тува, Алтайн хязгаар юм. Манай оронд чацарганыг үржүүлэх, тариалах агротехник, ОХУ-ын болон өөрийн орны 10 гаруй сортын чацарганыг нутагшуулах асуудлыг шийдвэрлэж, жимсийг хураах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах техник, технологийн үндсийг тавьж сүүлийн 40-өөд жилд түүнийг тариалж ирсэн байдлаас үзэхэд чацарганыг нутгийн аль ч цэгт түүний дотор Увс аймагт өргөн хэмжээгээр тариалж ашиглах бүрэн бололцоотой.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

“Чацаргана” хөтөлбөр дараах үе шатаар хэрэгжинэ.

2.2.1. Нэгдүгээр үе шат: 2006-2010 он хөтөлбөрийг сурталчлах, мэргэжил арга зүйн эвслөмж, сургалт мэдээллээр хангах, туршлага солилцох, үзүүлэх сургуулиуд зохион байгуулах, нийт иргэдийг хамруулан нэг айл өрх дундажаар 10-15 буттай болгохын тулд жилд 50.0-100.0 мянган суулгац үржүүлэх аж ахуйн нэгжүүд байгуулан дэмжиж чацаргана тариалах ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, борлуулалтын сүлжээ бий болгож экспортонд гаргах, чацаргана хураах ажиллагаа” хөнгөвчлөх, чацаргана боловсруулах техник технологийг сайжруулах

2.2.2 Хоёрдугаар үе шат: 2010-2016 он чацаргана тариалах ажлыг бүрэн механикжуулж техник, технологийг боловсронгуй болгож хүчин чадал ихтэй өндөр технологиор ажиллах, боловсруулах үйлдвэр шинээр байгуулах, өргөтгөх, байгалийн чацарганыг түүхий эд бэлтгэх нэг эх үүсвэр болгох, чацаргана тариалах ургац хураах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг өргөжүүлэн бие даасан салбар болгон хөгжүүлэх Чацарганыг Увсын, цаашилбал Монголын брэнд болгох.

Гурав. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага, зарчим

3.1 Хөтөлбөр боловсруулах шаардлага

3.1.1 Чацаргана, түүний бүтээгдэхүүн аливаа цацраг идэвхжилтийн хордлого тайлдаг, хамгаалдаг, хөлдөлт, түлэгдэлт, ходоод гэдэсний шархлааг анагаадаг зэрэг эмчилгээний олон үр дүнтэй нь нотлогдсон билээ. Мөн дэлхийн озоны давхарга цоорч цаг уур өөрчлөгдөж байгаа эрин үед чацаргана түүний бүтээгдэхүүн илүү эрэлт хэрэгцээтэй боллоо. Монгол хүн сансарт нисэхдээ энэ туршилт хийж нотолсон билээ. Эдгээрийг иш үндэс болгон Увс нутаг чацарганаараа брэнд бүтээх шаардлагатай гэж үзэв.

3.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчим баримтална.

3.2.1. Иргэдийн бүтээлч санал санаачлагыг шинжлэх ухааны ололттой зөв хослуулах чацаргана тариалах, ургац хураах боловсруулах, эмчилгээнд хэрэглэх, хадгалах технологийг шийдвэрлэж брэнд бүтээгдэхүүн “Чацаргана” байх боломжийг бүрдүүлнэ.

3.2.2. Чацарганыг дэлхийн төвшинд судалсан практикт суурилан, орон нутгийнхаа хэмжээнд бүтээлчээр хэрэгжүүлэхэд бүхий л ажлыг чиглүүлнэ.

3.2.3 Энэ ажлыг гүйцэтгэх, хүмүүсийн хүчин зүйлийг үнэлэх, чадавхийг сайжруулахад

бүх талын дэмжлэг үзүүлнэ.

3.2.4. Борлуулалт, үйлдвэрлэлтийн нэгдсэн сүлжээнд оруулахад дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4.1. *Хөтөлбөрийн зорилго.* Чацарганыг аймгийн бүх нутагт ергөн хэмжээгээр гарилж нийт иргэдийг хамруулах хөдөлгөөн өрнүүлж улмаар аймгийн нэрийн бүтээгдэхүүн болгох дотоод гадаадын зах зээлд тэргүүлэх хэмжээнд хүргэхэд оршино.

4.2 Хөтөлбөрийн зорилт

Дээрхи зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтууд дэвшүүлж байна.

4.2.1 Нэгдүгээр зорилт: Хөтөлбөрийн зорилго, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан ойлгуулах.

4.2.2 Хоёрдугаар зорилт: Манай аймагт нутагшсан өөрийн болон ОХУ-ын тослог сайтай, арвин ургац өгдөг сортын чацарганы суулгацыг бэлтгэж тариалах талбайг өргөжүүлэх.

4.2.3. Гуравдугаар зорилт: Чацарганы жимс хураах, үйлдвэрлэлийн аргаар боловсруулах технологи, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгож, чацарганы иж бүрэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах.

4.2.4 Дөрөвдүгээр зорилт: Хийгдсэн судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн ажлын үр дүн, гадаад орнуудын туршлагад тулгуурлан үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх.

4.2.5. Тавдугаар зорилт: чацаргана тариалах боловсруулах талаар хамтран ажиллах дотоод гадаадын иргэд аж ахуйн нэгж байгууллага сан, төсөл, хөтөлбөрүүдийн хүчийг ашиглан шинээр хоршоо, компани байгуулах чацарганы аж ахуй эрхлэлтийг бүх хүрээнд дэмжих.

4.2.6. Зургадугаар зорилт: чацарганы талаархи эрдэм шинжилгээний туршилт, судалгаа хийх, түүний ололт амжилт, гарч буй шинэ санал санаачлагыг дэмжиж нийтийн хүртээл болгох

4.2.7. Долдугаар зорилт: Байгалийн чацарганы талбайн тооллого хийх, хамгаалалтанд авах, эзэнжүүлэх, нөхөн сэргээлт хийх замаар нийт талбайн хэмжээг өсгөхийн хамт, чацарганыг айл өрхийн хашаанд тариалах, цөлжилт, хөрсний эвдрэлээс хамгаалахад өргөн ашиглах.

4.2.8 Наймдугаар зорилт: Гадаадын зах зээлд хамтран ажиллах түнштэй болох

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд

5.1.1. Хөтөлбөрийн зорилго, ач холбогдол үр ашиг- чацаргана тариалалт боловсруулалтын гадаад дотоодын туршлага, шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа шинжилгээний үр дүн, иргэдийн санал бодол, шинэ санаа туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах

5.1.2. Чацаргана үржүүлэх, үр ашгийг дээшлүүлэх талаар өргөн ярилцлагыг бүх сумдыг хамруулан зохион байгуулж “Чацаргана” судлаач эрдэмтэд энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийг оролцуулан Олон улсын бага хурлууд зохион байгуулах.

5.1.3 Чацарганаар хийж байгаа дэлхийн шилдэг бүтээгдэхүүн, түүнийг боловсруулж байгаа технологи, өөрийн аймагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг оролцуулан, үзэсгэлэн яармагийг сум, бүс, аймаг, улсын төвшинд зохион байгуулах

5.1.4 “Увсын брэнд” чацаргана болно гэдгийг улсын хэмжээнд мэдээлж зар, реклам явуулах

5.1.5 Чацаргана тариалалтаар амжилт олж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон практик ач холбогдолтой судалгаа шинжилгээний өгүүлэл бичсэн эрдэмтэн, судлаач мэргэжилтнийг шалгаруулан урамшуулдаг механизм бүрдүүлэх

5.1.6 “Чацаргана” тариалах, суулгац бэлтгэх үр шимийг ашиглах загвар төсөл боловсруулж нийтэд сурталчилах

5.2 Хоёрдугаар зорилтын хүрээнд

5.2.1. Улаангомьн ХААНТСтанцад эх цэцэрлэгтэй болгож чацарганы суулгац бэлтгэх газруудыг нэгдсэн бодлогоор байгуулах.

5.2.2. Чацарганы суулгац усалалтын систем томоохон голын хөндий түшиглүүлэн тарьж талбайн хэмжээг жил бүр 5-10 га-аар нэмэгдүүлэх.

5.2.3. Ажилгүйдэл, ядуурлын төслүүдийн эх үүсвэрээр чацаргана тариалах, чацарганажуулах төсөл хэрэгжүүлэх

5.3 Гуравдугаар зорилтын хүрээнд

5.3.1. Чацарганы жимс хураах ажиллагааг механикжуулах.

5.3.2. Жилд 300-500 тн жимс боловсруулах үйлдвэр, жижиг цехийг байгуулах, өмнө ажиллаж байсан үйлдвэрийг сэргээн шинэчлэх

5.4 Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

5.4.1. Чацарганы тос ялгаж авах технологийг сайжруулж жимс, бутны навч, хальсыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах судалгаа, туршилт явуулах.

5.4.2. Чацарганы тосыг 5-10 гр-аар савлах, шүүсийг эсгэхгүй хадгалах, технологи нэвтрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох

5.4.3. Чацарганы жимсийг бусад жимс, жимсгэнэ, цагаан идээ, арвайн гурил зэрэг бусад бүтээгдэхүүнээр баяжуулж олон нэрийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг бий болгох

5.4.4. Чацарганаар үйлдвэрлэсэн гоо сайхны бараа амтат дарс, ундаа, хүнсний

бараа, бүтээгдэхүүнийг дотоодын хэрэгцээнээс гадна гадаад зах зээлд гаргадаг болох.

5.5 Тавдугаар зорилтын хүрээнд

5.5.1 Төрийн соёрхолт эрдэмтэн Б.Лааганы бий болгосон “Чандмань” сортыг сэргээх

5.5.2. Чацаргана борлуулах төрөлжсөн сүлжээ байгуулж иргэд ААНБ-ын үйлдвэрлэсэн чацарганыг зах зээлд гаргах

5.5.3 Чацаргана тариалж байгаа иргэд аж ахуйн нэгжүүдийн суулгацны сортын чанарыг сайжруулах чацарганаар хийж байгаа бүтээгдэхүүний технологийг дэлхийн стандартад хүргэх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.

5.5.4 Чацарганы чиглэлээр ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг эхний 4 жилд орлогын албан татвараас чөлөөлүүлэх талаар холбогдох байгууллагуудад асуудал боловсруулж тавих.

5.5.5 Чацаргана тариалах түүний үр жимс боловсруулах, суулгац бэлтгэх чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй иргэд аж ахуйн нэгжид “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, гадаадын зээл тусламжийн хөрөнгөнөөс дэмжлэг үзүүлэх

5.5.6 Чацаргана боловсруулах технологийн тоног төхөөрөмжийг лизингээр оруулж ирэх ажлыг зохион байгуулах

5.6 Зургадугаар зорилтын хүрээнд

5.6.1 Чацаргана судлалаар ажиллаж буй судлаачид, мэргэжилтнүүдийг дэмжиж олон улсын хурал, энэ чиглэлээр үр дүнд хүрч байгаа улс оронд явуулах, сургаж мэргэжүүлэх.

5.6.2 Чацаргана судлалаар эрдэм шинжилгээний илтгэл ном бичих, орчуулах уралдаан болзол зарлаж дүгнэж урамшуулах

5.6.3. Чацарганы аж ахуй хөгжүүлж үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, тэргүүн туршлага, шинжлэх ухааны ололтуудыг хэвлэл радио, телевизээр нийтийн хүртээл болгохын чацуу төрөлжсөн товхимол, зурагт хуудас, гарын авлага болгон түгээх

5.7. Долдугаар зорилтын хүрээнд

5.7.1. Хүмүүсийн буруу үйл ажиллагаа болон ган, усны үерийн улмаас сүйдэж доройтсон байгалийн чацарганы талбайд нөхөн тарилт, шигүү ургасан хэсэгт сийрэгжүүлэлт хийх, эзэнжүүлэх, Ногоон хэрэм хөтөлбөрийн хүрээнд ойн зурваст чацаргана тариалах

5.7.2. Чацаргана тариалж болох газар нутгийн судалгаа гаргах

5.8. Наймдугаар зорилтын хүрээнд

5.8.1 ОХУ-ын Барнаул, Японы Ибараки, Энэтхэг зэрэг хот, муж улсуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх

5.8.2 Чацарганы чиглэлээр мэргэшсэн гадаад дотоодын хүмүүсийг урьж лекц уншуулах, туршлагыг нь түгээх

5.8.3 “Чацаргана” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ засгийн газрын бусад хөтөлбөр, Олон улсын хандивлагчдаас хэрэгжүүлж байгаа төслүүдтэй нягт уялдуулах

5.8.4 Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлсэд орон нутгийн эрдэм шинжилгээний байгууллага төрийн болон төрийн бус байгууллагуудыг өргөнөөр оролцуулах

Зургаа. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шалгуур үзүүлэлт

6.1 Чацарганаар хийсэн бүтээгдэхүүн түүний үйлчилгээ нь дараах шалгуур үзүүлэлтүүдийгхангасан байна.

6.1.1. Чацаргана нь Увс аймгийн нутагт бүрэн нутагшсан өөрийн онцлог давуу чанаруудыг агуулсан байна.

6.1.2 Нэг бутнаас авах жимс, жимсгэнд агуулагдах тос, амин дэмийн болон хүний организмд хэрэгтэй микро элементүүдийн агууламжаараа бусад газарт ургаж буй чацарганатай адил буюу илүү байх.

6.1.3 Чацарганы суулгац, бүтээгдэхүүнүүд нь Олон улсын стандартаар баталгаажсан, чанарын тэмдэг, бүтээгдэхүүний /лого/-той болсон байх.

6.1.4. “Чацаргана хөтөлбөр хэрэгжсэнээр ажилгүйдэл, ядуурал буурч иргэдийн орлого нэмэгдэх.

6.1.5 Хөтөлбөр хэрэгжсэнээр татварын бааз суурь өргөжих.

6.1.6 Энэ хөтөлбөрийгхэрэгжүүлэх нь байгаль орчинд ямарч халгүй төдийгүй ногоон бүс нэмэгдсэн байх.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

7.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1.1 Аймгийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий аймгийн зөвлөл нь дэргэдээ зөвлөх баг, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах зохицуулагч ажилтантай байна. Сумдад салбар зөвлөлүүд ажиллана.

7.1.2 Хөтөлбөрийн зөвлөлийг аймгийн Засаг дарга удирдах бөгөөд түүний бүрэлдэхүүнд аймгийн ИТХурлын төлөөлөгч.чацарганы холбооны төлөөлөл, төсөл, хөтөлбөрийн ба эрдэм шинжилгээний ажилтнууд, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүд, иргэд, ААНБ-ын төлөөлөл орсон байна.

7.1.3 Зөвлөх багийг чацарганы асуудлаар судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг эрдэмтэд, чацарганаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд ,аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оролцуулан аймгийн Засаг даргын захирамжаар томилно.

7.1.4 Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хариуцсан зохицуулагч, ажилтан боловсруулж аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

7.1.5 Аймгийн Засаг дарга хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

7.1.6 “Чацаргана” сан байгуулна.

7.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

7.2.1 Иргэдийн өөрсдийн хөрөнгө

7.2.2 Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө

7.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө, өмч хувьчлалын орлого

7.2.4 Орон нутгийн орлогын тухайн жилийн давсан хэсэг.

7.2.5 Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө

7.2.6 Бусад

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

8.1 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

- 8.1.1 Чацарганы суулгац бэлтгэлт, тариалсан бут, иргэн өрх, аж ахуйн нэгж байгууллагын тоо, хураасан жимсний хэмжээ, жил бүрийн өсөлтийн хувь.
- 8.1.2 Борлуулалтын орлогын өсөлт
- 8.1.3 Экспортонд гаргасан тоо хэмжээ, орлогын өсөлт
- 8.1.4 Шинээр бий болсон ажлын байрны тоо, өсөлт
- 8.1.5 Хөрөнгө оруулалт, түүний өсөлт
- 8.2 Тухайн жилийн эхэнд хөтөлбөрийн хүрээнд хүрэх шалгуур үзүүлэлтийг аймгийн зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, дараа онд дүгнэж нийтэд мэдээлж байна.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

9.1 Гарах үр дүн

- 9.1.1 Чацаргана тариалах талбайг нэмэгдүүлж, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулна.
- 9.1.2 Чацарганыг дотоодын хэрэгцээнээс гадна экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбар болгон хөгжүүлнэ.
- 9.1.3 “Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд байгуулах ойн зурвас, уул уурхайн ашигт малтмалыг олборлох явцад эвдэрсэн хөрсөнд болон элсний нүүдэл зогсоох, байгалийн Чацарганы талбайг нөхөн сэргээх, өргөжүүлэхэд шаардлагатай суулгацыг тогтмол бэлтгэдэг материаллаг баазтай болсон байна.
- 9.1.4 Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад Чацарганы аж ахуй, үйлдвэрлэлээр дагнан ажиллах 1500-аас доошгүй ажлын байр бий болно.
- 9.1.5 Жилд дотоод гадаад зах зээлд 1000 тн чацаргана нийлүүлдэг болсон байна.
- 9.1.6 Нийт 1500-аас доошгүй га-д чацаргана тариалдаг болсон байна.